

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Агуулга.....	2
1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БИОКОМБИНАТ УТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.ЦОЛМОН ТАНАА

2020.03.13 № 06/876
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтад заасны дагуу “Биокомбинат” УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Биокомбинат” УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Биокомбинат” УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Биокомбинат” УТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Биокомбинат УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Биокомбинат УТҮГ-ын захирал Б.Цолмон Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйлдвэрлэл үйлчилгээний онцлогт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх, Төрийн өмчийн эзэмшлийн дүнг байгууллагын дүрэм, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлэх, зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Биокомбинат УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Үйлдвэрийн газрын захирал санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, үйлдвэрийн газрын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Ихмонгол хөлөг Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Биокомбинат УТҮГ нь 2019 оны санхүүгийн тайланг “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасан цаглабараас 2 хоног хоцорч 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 3/124 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Биокомбинат УТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгоо Шинжлэх ухаанд суурилсан малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх оношлох, эмчлэх биобэлдмэлийг үйлдвэрлэж, чанарын баталгаатай бүтээгдэхүүнээр хэрэглэгчийг хангах, хамтын хөгжлийг дээдлэгч мал эмнэлгийн тэргүүлэх салбар байна гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ;
- Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хэмжээ;
- Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2019 оноос мөрдөж эхэлсэн;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж нээлттэй мэдээлэх;
- Засгийн газрын “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны 276 тугаар тогтоолоор цалингийн зэрэглэл өөрчлөгдсөн.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Биокомбинат УТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Биокомбинат УТҮГ-ын нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous 4.0” программ хангамж ашигладаг байна.

Биокомбинат УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Биокомбинат УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 16 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,564.2 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 25.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 70.5 сая төгрөгөөр материаллаг түвшин тогтоосон нь тайлант оны суурь үзүүлэлтийн дүнгээс тооцсонтой холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Биокомбинат УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө, нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн өмнөх оноос 1,188.0 сая төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,149.2	1,329.5	180.3
Авлага	502.4	191.5	(310.9)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	2,776.1	2,272.5	(503.6)
Урьдчилж төлсөн зардал тооцоо	8.8	7.9	(0.9)
Үндсэн хөрөнгө	13,968.9	13,285.4	(683.5)
Дуусаагүй барилга	-	130.6	130.6
Нийт хөрөнгө	18,405.4	17,217.4	(1,188.0)
Өр төлбөр	1.1	153.4	152.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	18,404.3	17,064.0	(1,340.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	18,405.4	17,217.4	(1,188.0)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь тайлант хугацааны борлуулалт өсч, арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл буурсан нь Цонбон тоосго ХХК, Цэцүүх трейд ХХК-иас авах нийт 329.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэл төлөгдсөнөөс шалтгаалж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 519.1 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн борлуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь 1,006.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл өссөн нь Грийн химистри ХХК, Хазаарбат ХХК, Орон нутгийн мал эмнэлгийн газрууд болон татварын байгууллагад төлөх 153.4 сая төгрөгийн үлдэгдлээс шалтгаалсан байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Биокомбинат УТҮГ-ын Мал эмнэлгийн ерөнхий газар, орон нутгийн мал эмнэлгийн газруудтай нийт 5,560.3 сая төгрөгийн Мал эмнэлгийн зориулалт бүхий биобэлдмэл 2019 онд худалдах, худалдан авах гэрээг байгуулж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/43 дугаар тушаалаар 5,862.3 сая төгрөгийн зардлын төлөвлөгөөг баталсан байна.

Биокомбинат УТҮГ нь тайлант хугацаанд 5,704.3 сая төгрөгийн орлого олж, 7,044.6 сая төгрөгийн зардал гаргаж, 1,340.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 16 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 8,595.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 8,592.8 сая төгрөгийн алдааг залруулж, 2.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны үндсэн үйл ажиллагааны орлогын дүнг 3,000.0 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.2-т “Тасралтгүй байх”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн гүйлгээний тайланд залруулсан.

2. Нийт 5,592.8 сая төгрөгийн борлуулалтын орлогыг бүртгэхдээ мөнгөн сууриар бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг, үнэлгээ батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлд залруулсан.

3. Шилэн дансны цахим хуудсанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн зөвлөмжийн тайланг мэдээлээгүй байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-т “...аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор...”, “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.3-т “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад шилэн дансны цахим хуудсанд нөхөж мэдээлсэн.

4. Тайлант хугацаанд нийт 27 ажилтанд аймаг, хот, сумдад албан томилолтоор ажиллаж байх хугацаанд хоолны хөнгөлөлтийг давхардуулан 2.6 сая төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2-т “Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ”, 2.2.1-т “унааны зардал”, 2.2.2-т “байрны зардал” 2.2.3-т “хоолны зардал” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэлгээ ба хэмжилт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

5. Өмнөх аудитаар Үйлдвэрлэлийн онцлогийг тусгасан санхүүгийн программ нэвтрүүлэх, төлбөрийн баримт /и баримт/-гүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө”, 4.1.6-д “Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй” гэж заасан, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх.

6. Байгууллагыг улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлэхдээ эхлэлийн балансад тусгагдсан төрийн өмчийн дүнг улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмд тусгаагүй байна. Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-т заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын

бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга, батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хулийг мөрдөж ажиллах албан шаардлага өгөх.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмд төрийн өмчийг бүртгүүлсэн эсэхийг, орлогын төлөвлөгөөг батлуулсан эсэх, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 186 дугаар тогтоолын хэрэгжилт, Ерөнхий нягтлан бодогчийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу томилсон эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Биокомбинат УТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 3 мэдээллийг аудитын явцад мэдээлсэн.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Өмнөх аудитаар 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгснөөс акт, албан шаардлагын биелэлтийг бүрэн хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид "Биокомбинат" УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

"Биокомбинат" УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалтын талаар

3.1.1. Илрүүлэлт:

Байгууллага нь Ерөнхий нягтлан бодогчгүй, тус албан тушаалыг түр орлон гүйцэтгэж байгаа тооцооны нягтлан бодогчийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд түүнийг Сангийн яамны зөвшөөрөлтэйгээр захирал томилно" гэж заасантай нийцээгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа тасалдах

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын ерөнхий нягтлан бодогчийг хууль тогтоомжийн дагуу томилж ажиллуулах.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-385 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хууль, журам, зааврын өөрчлөлтийг тусгаж хөдөө аж ахуйн салбарын бүх байгууллагад мөрдүүлэхээр олгосон боловч Биокомбинат УТҮГ-ын үйлдвэрлэлийн онцлогтой уялдаагүй байна. Энэ нь НББОУС 8.14-т а) өөрчлөлтийг СТОУС-аар шаардсан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

3.2.2. Эрсдэл:

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, нягтлан бодох бүртгэлийн зарчим алдагдах

2.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйлдвэрлэл үйлчилгээний онцлогт нийцүүлэн холбогдох өөрчлөлтүүдийг тусган шинэчлэн боловсруулж баталж, мөрдөх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,149,235,698.74	1,329,537,771.57
Дансны авлага		
Татвар, НДШ – ийн авлага		
Бусад авлага	502,385,366.16	191,537,049.10
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	2,776,063,994.46	2,272,498,779.46
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,755,843.42	7,896,576.75
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
Эргэлтийн хөрөнгийн дүн	4,436,440,902.78	3,801,470,176.88
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	9,364,836,049.30	8,684,213,153.22
Биет бус хөрөнгө	4,604,071,480.00	4,601,068,480.00
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Дуусаагүй барилга		130,627,379.54
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13,968,907,529.30	13,415,909,012.76
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	18,405,348,432.08	17,217,379,189.64
Эргэлтийн бус хөрөнгө		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	1,060,753.00	151,169,586.14
Цалингийн өглөг		
Татварын өр		
НДШ - ийн өглөг		2,240,878.00
Богино хугацаат зээл		
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого		
Нөөц /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,060,753.00	153,410,464.14
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл		
Нөөц /өр төлбөр/		
Хойшлогдсон татварын өр		
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	1,060,753.00	153,410,464.14

ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Өмч: төрийн	2,141,020,492.31	2,141,020,492.31
- хувийн		
- хувьцаат		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,477,130,741.70	8,944,423,800.98
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эздийн өмчийн бусад хэсэг	6,068,361,539.28	4,601,068,480.00
Хуримтлагдсан ашиг	2,717,774,905.79	1,377,455,952.21
Эзэмшигчдийн өмчийн дүн	18,404,287,679.08	17,063,968,725.50
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	18,405,348,432.08	17,217,379,189.64

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	1,122,861,119.96	5,591,547,523.92
Борлуулалтын өртөг		
Нийт ашиг(алдагдал)	1,122,861,119.96	5,591,547,523.92
Түрээсийн орлого		
Хүүний орлого		10,278,147.95
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		82,976,932.62
Борлуулалт, маркетингийн зардал	717,188,328.06	6,639,303,264.11
Ерөнхий ба удирдлагын зардал	206,993,237.29	235,412,925.96
Санхүүгийн зардал		
Бусад зардал	1,639,975,377.31	169,842,333.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(43,534.00)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		19,480,499.03
Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(1,441,295,822.70)	(1,340,318,953.55)
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг (алдагдал)	(1,441,295,822.70)	(1,340,318,953.58)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,441,295,822.70)	(1,340,318,953.58)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлээний дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	2,259,619,642.98	5,125,878,054.93
Бараа борлуулсан үйлчилгээний орлого	2,259,619,642.98	5,125,798,138.93
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		79,916.00
Буцаан авсан албан татвар		
Татаас санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого		
Мөнгөн зарлагын дүн	1,834,056,277.00	4,804,088,572.02
Ажилчдад төлсөн	522,507,966.15	2,436,191,437.49
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	45,492,068.00	328,740,512.72
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	159,103,594.58	1,356,446,171.31
бичиг хэргийн зардал		6,607,970.00
Ашиглалтын зардалд төлсөн	374,357,402.00	318,284,131.73
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	33,817,426.00	
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн		
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	698,777,820.27	357,818,348.77
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	425,563,365.98	321,789,482.91
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	10,740,547.92
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого		10,740,547.92
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн	39,929,000.00	152,191,294.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	39,929,000.00	152,191,294.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(39,929,000.00)	(141,450,746.08)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Валютын ханшийн зөрүү		
Мөнгөн зарлагын дүн		36,664.00

Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө		
Хувьцаа буцааж худалдан авахад төлсөн мөнгө		
	-	36,664.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(36,664.00)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	385,634,365.98	180,302,072.83
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	763,601,332.76	1,149,235,698.74
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,149,235,698.74	1,329,537,771.57

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,141,020,492.31	1,467,293,059.28		4,159,070,728.49	7,767,384,280.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					-
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт			4,601,068,480.00		4,601,068,480.00
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		7,477,130,741.70		(1,441,295,822.70)	6,035,834,919.00
2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,141,020,492.31	8,944,423,800.98	4,601,068,480.00	2,717,774,905.79	18,404,287,679.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,340,318,953.58)	(1,340,318,953.58)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-		-
Өмчид гарсан өөрчлөлт		-			-
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,141,020,492.31	8,944,423,800.98	4,601,068,480.00	1,377,455,952.21	17,063,968,725.50
Тайлант үеийн цэвэр ашиг					-
Ногдол ашиг					-
Гаргасан хувьцаат капитал					-
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,141,020,492.31	8,944,423,800.98	4,601,068,480.00	1,377,455,952.21	17,063,968,725.50

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Биокомбинат УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2019.12.31			САГ-2020/15/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	БИОКОМБИНАТ УТҮГ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллага нь ерөнхий нягтлан бодогчгүй, санхүүгийн төлбөр тооцоог гүйцэтгэх, мэдээлэх, тайлагнах ажлыг тооцооны нягтлан бодогч Э.Энхмөрөн тушаал шийдвэргүйгээр гүйцэтгэж байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга	Б.Цолмон
2	Хүнс Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-385 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хууль, журам, зааврын өөрчлөлтийг тусгаж хөдөө аж ахуйн салбарын бүх байгууллагад мөрдүүлэхээр олгосон нь Биокомбинат УТҮГ-ын үйлдвэрлэлийн онцлогтой уялдаагүй байна	-	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Цолмон Э.Энхмөрөн
3	Тайлант хугацаанд нийт 27 ажилтанд аймаг, хот, сумдад албан томилолтоор ажиллаж байх хугацаанд хоолны хөнгөлөлтийг давхардуулан 2.6 сая төгрөгийг илүү олгосон байна.	2.6	Төлбөрийн акт тогтоох	Нягтлан бодогч	Э.Энхмөрөн
4	Өмнөх аудитаар Үйлдвэрлэлийн онцлогийг тусгасан санхүүгийн программ нэвтрүүлэх, төлбөрийн баримт /и баримт/-гүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх зөвлөмжийг бүрэн хэрэгжээгүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Дарга Нягтлан бодогч	Б.Цолмон Э.Энхмөрөн
5	Байгууллагыг улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлэхдээ эхлэлийн балансад тусгагдсан төрийн өмчийн дүнг улсын бүртгэлийн гэрчилгээ, болон дүрмэнд тусгаагүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Дарга Нягтлан бодогч	Б.Цолмон Э.Энхмөрөн
НИЙТ ДҮН		2.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 03 дугаар сарын 24

№ 02/73

Улаанбаатар хот

САГ- 20 20/15/СТА- ТӨМГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цагалбарт хугацаанд хийсэн "Биокомбинат" УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд нийт 27 ажилтанд аймаг, хот, сумдад албан томилолтоор ажиллаж байх хугацаанд хоолны хөнгөлөлтийг давхардуулан 2,584,000.00 төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ", 2.2.1-т "унааны зардал", 2.2.2-т "байрны зардал" 2.2.3-т "хоолны зардал" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, хэмжилт ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон хоолны мөнгө 2,584,000.00 /хоёр сая таван зуун наян дөрвөн мянган/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Биокомбинат" УТҮГ-ын захирал Б.Цолмон, нягтлан бодогч Э.Энхмөрөн нарт хариуцуулав.

ТОГТООСОН:
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 Ц.НАРАНЧИМЭГ
 АУДИТОР
 Ч.ДАШДАВАА

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
 ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
 ЗАХИРАЛ

С.ТУНГАЛАГ

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:
 ЗАХИРАЛ

Б.ЦОЛМОН

НЯГТЛАН БОДОГЧ
 1118272532 ш. 8292485

Э.ЭНХМӨРӨН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь салах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтныг хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kherem\Akt\2020\0323SAG1 Docx

001090187



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 24

№ 02/158

Улаанбаатар хот

САТ- 2020/15/САТ-ТӨМГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цагалбарт хугацаанд хийсэн "Биокомбинат" УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар Үйлдвэрлэлийн онцлогийг тусгасан санхүүгийн програм нэвтрүүлэх, төлбөрийн баримт /и баримт/-гүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.6-д "Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй" гэж заасан, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/124 дүгээр тушаал гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн аудитын байгууллагын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг хийсэн "Биокомбинат" УТҮГ-ын захирал Б.Цолмон, ерөнхий нягтлан бодогч Э.Энхмөрөн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

<p>ӨГСӨН: САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР АУДИТОР <i>Ц.НАРАНЧИМЭГ</i> <i>Ч.ДАШДАВАА</i> ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ <i>С.ТУНГАЛАГ</i></p>	<p>ЗАХИРАЛ НЯГТЛАН БОДОГЧ:</p>	<p>ЗӨВШӨӨРСӨН: <i>Б.Цолмон</i> <i>Э.Энхмөрөн</i> 1118272532 ± 8292485</p>
		<p>Б.ЦОЛМОН Э.ЭНХМӨРӨН</p>

Акт, албан шаардлагын биелэлт хангаагдсангүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагын тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь ташах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцагч тоонуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 24

№ 02/159

Улаанбаатар хот

САГ- 2020/15/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цагалбарт хугацаанд хийсэн "Биокомбинат" УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагыг улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлэхдээ эхлэлийн балансад тусгагдсан төрийн өмчийг улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмд тусгаагүй байна. Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/124 дүгээр тушаал гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг хийсэн "Биокомбинат" УТҮГ-ын захирал Б.Цолмон, ерөнхий нягтлан бодогч Э.Энхмөрөн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР *Ц.Наранчимэг*
Ч.ДАШДАВАА

ЗАХИРАЛ
НЯГТЛАН БОДОГЧ:
Б.ЦОЛМОН
Э.ЭНХМӨРӨН

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ *С.Тунгалаг*
С.ТУНГАЛАГ



Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь таслах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариулага тусуулахыг эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

